



- Хэрэв та зөв хүүхдийн суудлыг бэхлэсэн бол, суудал хөдлөхгүй байх ёстой.
- МАШИНЫ СУУДЛЫГ СУЛ БЭХЛЭХ НЬ = ХҮҮХДЭЭ ТА МУУ БЭХЛЭСЭН!
- Хүүхдийн суудлыг худалдан авахдаа сайн шалга, гэмтэл байна уу зааврын дагуу хийгдэх эсэх. МАШИНЫ СУУДАЛ АЖИЛЛАДАГ БАИХ ЁСТОЙ!
- Машин гэнэтийн, торомслох эсвэл мөргөлдөхөд хүн маш их хэмжээний хүчтэй урагшлана. Жишээ нь 50 км хурдтай мөргөлдөхөд 10 кг хүүхэд дээр 300 кг хүчтэй цохилт үүсэнэ!
- Хэрэв машинд хүүхдээ тэвэрч явах үед мөргөлдөхөд – хэзээч хүүхдийг барьж чадахгүй. Өөрийн биеийн жингээр хүүхдээ няцалж болох осол гарна.
- Хэрэв өөрийгөө болон хүүхдээ нэг бүсээр хамт бүслэх тохиолдолд машин мөргөлдөхөд өөрийн жингээр хүүхдээ бяцална.
- Жижиг хүүхдийг (150 см-ээс намхан хүүхдийг) хүүхдийн зориулалтын машины суудлыг хэрэглэнэ, бүс нь хоолойгоор давуулан буруу бэхлээл осол аваар болоход хоолойг нь хэрчих ба бооно.
- Хот дотор ба ойрхон богино хугацаанд явахдаа хүүхдээ дандаа бэхлэх(сургууль руу, дэлгүүр).
- Аваарын бүсийг өөрөө дандаа бүслэж хүүхдүүддээ үлгэр жишээч бай!

Жолооч „Аваарын бүсийг бүслээгүй“ хэрэглээгүй нөхцөлд зам тээврийн гэмт хэрэг үйлдсэн хэрэгт орж 3 оноо өөрийн хэргийн бүртгэлд бичигдэнэ мөн жолоочид 2000 крон хүртэл газар дээр торгууль оногдуулах боломжтой.

Жолооч „Хүүхдийг машины суудалд суулгаагүй“ нөхцөлд зам тээврийн гэмт хэрэг үйлдсэн хэрэгт орж 4 оноо өөрийн хэргийн бүртгэлд бичигдэнэ мөн жолоочид 2000 крон хүртэл газар дээр торгууль оногдуулах боломжтой.



Чех Улсад 150 см-аас бага өндөртэй мөн 36 кг-аас бага жинтэй хүүхдүүд суудлын машинаар зорчихдоо заавал хүүхдийн суудлыг хэрэглэх хуультай, тэр суудал нь өөрийн жин ба өндөрт зориулсан суудал байх ёстой. Хүүхдийн өндөр ба жин нь энэ хэмжээнээс хэтрэх тохиолдолд зөвхөн суудлын бүсийг хэрэглэнэ.



Нярай хүүхэд
0 – 13 кг (0 - 9/12 сартай)

Нярай хүүхдийг хагас дугуй хэлбэртэй зориулалтын суудалд (бүрхүүл) хэвтээ байдлаар тээвэрлэхийг зөвшөөрнө. Ийм суудлыг дандаа машины хөдөлгөөний эсрэг харуулан бэхлэнэ. Хүүхдийн энэ суудлыг машины арын суудалд бэхлэх нь сайн гэж зөвлөнө.

Анхаар – хэрэв хүүхдийн суудлыг машины урд суудал дээр бэхлэх, тэнд аваарын дэр айрбек идэвхигүй байх ёстой. Аваарын дэр айрбекиг унтрааж болохгүй газар хүүхдийн суудлыг бэхлэхгүй. Идэвхитэй аваарын дэр айрбек нь хүүхдэд аюултай!

Хэрэв хүүхдийн жин хагас дугуй хэлбэрийн суудлаас хэтрэх, эсвэл хүүхдийн толгой хагас дугуй хэлбэрийн суудлаас илүү гарах тохиолдолд, хүүхдийн жинд тохирсон хүүхдийн шинэ суудлыг сонгон авна.

	<p>Používejte správný zadržný systém pro vaše dítě podle jeho hmotnosti a velikosti.</p> <p>VZDY</p>		<p>Nevozte dítě na křídle nebo zajištěné bezpečnostním pásem pro dospělé spolu s vámi. Při nehodě byste mohli dítě rozdrtit.</p> <p>NIKDY</p>
---	---	---	--

Та хүүхдийн жин ба өндрийн хэмжээнд тохируулан хязгаарлах системийг хэрэглэх ёстой.

Хүүхдээ өвөр дээр битгий авч яв мөн нэг бүсээр хамт битгий бөхлө. Аваар болоход хүүхдээ бяцлана.

	<p>Pamatajte, že můžete zabudovat dětskou korbíčku i na zadní sedadlo vozu.</p> <p>VZDY</p>		<p>Neumisťujte dětskou autosedačku na místo s aktivním airbagem.</p> <p>NIKDY</p>
---	--	---	--

Хүүхдийн хагас дугуй хэлбэртэй суудлыг машины арын суудалд бэхлэж болно гэдгийг битгий мартаарай.

Хүүхдийн хагас дугуй хэлбэртэй суудлыг идэвхитэй арбектэй газар бэхлэхгүй.